



A large, faint architectural sketch of a modern building complex occupies the lower half of the image. It features multiple levels, overhanging eaves, and a mix of glass and brickwork. A prominent curved roofline is visible on the right side. The sketch is rendered in light gray lines on a white background.

ТӨВШИН БОГД ХХК

2006-2024

[WWW.TUVSHINBOGD.MN](http://WWW.TUVSHINBOGD.MN)

# БИДНИЙ ТУХАЙ



Төвшин богд ХХК нь 2006 онд барилга угсралт, засал чимэглэлийн чиглэлээр үүсгэн байгуулагдсан бөгөөд өдгөө 16 жилийн туршлага хурумтлуулсан 4 салбар нэгж бүхий компани болон өргөжин ажиллаж байна. Байгуулагдсан цагаас эхлэн олон улсын, хувийн хэвшлийн, Монгол улсын нийт 60 орчим төслүүдийг олон улсын болон дотоодын барилгын стандартын дагуу амжилттай гүйцэтгэж гэрээний дагуу хүлээлгэн өгсөн байна.

Манай компани харилцагчдынхаа эрэлт хэрэгцээ, хүсэлт, шаардлагад бүрэн нийцэн ажиллахыг үргэлж эрмэлзэн ажилладаг бөгөөд байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын ТОП-100 татвар төлөгч компаниудын төлөөлөлтэй хамтран ажиллаж ирснийг дурдахад таатай байна.



## Төвшин богд ХХК-ы зорилго, алсын хараань:

- Аюулгүй ажиллагааг бүрэн хангах
- Орлогоо ёсгөн нэмэгдүүлэх
- Бүтээгдэхүүний өндөр чанарыг дээдлэх
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн баталгаа болох
- Эрэг имижтэй
- Бүтээмжэ нэмэгдүүлэх
- Дэлхийн болон дотоодын стандартыг цаг алдалгүй дагаж мөрдөх
- Зах зээлд эзлэх хувь нэмэгдүүлэх
- Аз жаргалтай ажилчид, сайн ажиллах нөхцөл бүрдүүлэх
- МУ-ын Хууль тогтоомж, стандартыг хүндэтгэх



АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА НОГООН ИРЭЭДҮЙ



ДЭЛХИЙН СТАНТАРТ



ХУУЛЬ ДЭЭДЛЭХ

Яагаад “Төвшин богд” ХХК сонгох хэрэгтэй вэ?

Манай компаний дараахи зарчмуудыг баримтлан ажилладаг учраас манай харилцагчид бидэнтэй хамтран ажиллахдаа үргэлж таатай байдаг.

1. Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийг ягштал баримталдаг.
2. Ногоон хөгжил, байгаль орчинд ээлтэй бодлого явуулдаг.
3. Аюулгүй ажиллагааг 100% хангадаг.
4. Чанар, стандартын шаардлага баримталдаг.

Бидэнд итгэл хүлээлгэдэг, байнгын хамтран ажиллагч та бүхэндээ баярлалаа.



SHUNKHLAI



MONGOLIA'S  
WORLD CLASS  
MINING COMPANY



ТАВАН БОГА ГРУПП  
Хамтын хүч - Амжилтын тулхүүр



СОД МОНГОЛ ГРУПП



APU COMPANY  
Absolute. Pure. Unique.

MONNIS  
The Group

УЛААНБААТАР ПРИНТ ХХК  
Diamond Print

APU TRADING  
Absolute. Pure. Unique.

BEREN  
BEREN GROUP

ЭС ДЕВЕЛОПМЕНТ

# ЧАДВАР, ХҮНИЙ НӨӨЦ

Манай компани сүүлийн 5 жилийн хугацаанд дотоод чадавхia байнга ёсгөн нэмэгдүүлж ТЭЗҮ төлөвлөлт, зураг төсөл, төслийн менежмент, барилга угсралт, график дизайн, тоног төхөөрөмж сууринуулалт, барилгын засвар үйлчилгээ, машин механизмын бааз, тээвэр ложистикийн салбаруудынхаа үйл ажиллагааг эрчимжүүлж, тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

2024 оны III улиралд ИТА, ажилчид 120 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Нийт ажилчдын бүрэлдэхүүн 100% дотоодоос бөгөөд туршлагатай мэрэгжлийн баг хамт олон барилга угсралт бүхий бүтээн байгуулалтын төслийг эхний шатны санал санаачилгаас эхлэн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хүлээлгэн өгөх, зүгшрүүлэх шат хүртэл цогц бөгөөд аюулгүй, чанартай гүйцэтгэн ажилласаар ирсэн.

## САНХҮҮГИЙН БАЙДАЛ

Сүүлийн гурван жилийн санхүүгийн товч.

- ° 2022 онд нийт 5.537.521.500,00₮  
° Үүнээс цэвэр ашиг 1.537.509.00,00₮
- ° 2023 онд нийт 5.902.133.120,00₮  
° Үүнээс цэвэр ашиг 1.276.543.890,00₮
- ° 2024 онд нийт 6.694.155.141,00₮  
° Үүнээс цэвэр ашиг 1.686.537.270,00₮



## МАНАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Олон нийтийн, иргэний, үйлдвэрийн, уул уурхайн, зам гүүрний барилгын салбарт манай компани дараах үйлчилгээг үзүүлэн ажилладаг ба цаашид дэлхий дахины барилгын салбарт эрэлт нь ёсөн нэмэгдэж буй шинэ технологийг нэвтрүүлэхээр судалгааны ажлууд хийгдэж байна.

Үүнд:

- 5D BIM технологи /5-D Building Information Modeling/
- Дижитал хамтын ажиллагаа ба хөдөлгөөнт байдал /Collaboration and Mobility/
- IoT ба дэвшилтэт анализ /IoT and Advanced Analytics/
- HD маркшейдер ба газарзүйн байршил /HD Surveying and Geolocation/

A

БАРИЛГА УГСРАЛТ, ЗАСАЛ ЧИМЭГЛЭЛ,  
ГАДНА ТОХИЖИЛТ

B

ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ

C

ЗУРАГ ТӨССӨВ

D

ТЭЭВЭР ЛОЖИСТИК



# ЗУРАГ ТӨСӨЛ

Тасралтгүй хөгжиж буй орчин үеийн барилгын салбарын уураг тархи нь болсон зураг төслийн ажлын хамт олон маань Монгол улсын MNS 3757-1 : 2003 болон ОУ-ын COMPUTER-AIDED DESIGN (CAD) ISO 3098-5:1997, ISO 11442:2006, ISO 13567-1:2017, ISO 13567-2:2017, ISO 16792:2021, ISO/CD 24351 зэрэг стандартыг баримтлан захиалагчийн даалгаврын дагуу, норм дүрмийн өндөр түвшинд гүйцэтгэж ирсэн.

Цаашид барилгын архитектур, угсралт, дэд бүтцийн хамтын шийдэл болох BIM AUTODESK REVIT /building information model-барилгын цогц мэдээллийн модель/ программ хангамжийг өөрийн компанийд нэвтрүүлэхээр ажиллаж байгааг дуулгахад таатай байна.

## ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ

Төслийн менежментийн баг хамт олны сүүлийн 10 жил хуримтлуулсан туршлагад тулгуурлан аливаа төслийг үр ашигтай менежментээр хангах үндсэн зорилгоо манай чадварлаг баг хамт олон ARCDSEK, OMNITRACKER программ хангамжийн стандартын дагуу амжилттай биелүүлэн ажиллаж ирлээ.

Төслийн менежментийн бүх үе шатанд, манай хамт олон тантай хамт байх болно.

1. Зураг төсөл.
2. Барилгын төсөв.
3. Эрсдэлийн үнэлгээ.
4. Барилга угсралтын төлөвлөгөө.
5. Барилга угсралтын хяналт.
6. Байгууллагын ажиллах хүч, тоног төхөөрөмжийг зохион байгуулах.
7. Барилга хүлээлгэн өгөх.




# ХАБЭА ХЭРЭГЖИЛТ

Өөрийн компанийн байранд шинээр ажилд орж буй болон ажил үүргийн хуваарь солигдсон хүний нөөцдөө аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, чанар стандартын сургалт тогтмол явуулж, Монгол Улсын Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын сайдын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг ханган ажиллахын зэрэгцээ олон улсын стандарт AS/NZS 4801, байgal орчны EMS ISO 14001 мөрдлөгө болгон ажиллаж нийт 16 жил аваар осолгүй, орчны сөрөг нөлөөний муу үнэлгээгүй ажиллаж байна.



ХАБЭА өдөр тутмын зааварчилгасны оч холбогдол



1. Урьдчилсан зааварчилгаа
2. Анхан шатны зааварчилгаа
3. Давтан зааварчилгаа
  - 3.1 Ээлжит
  - 3.2 Ээлжит бус давтан
  - 3.3 Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа
4. Өдөр тутмын зааварчилгаа

# ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛҮҮД

## Иргэний болон нийтийн барилга угсралт, засвар

2006-2024 он хүртэл нийт 12 иргэний болон нийтийн барилга угсралт болон бүрэн засварын ажил гүйцэтгэсэн бөгөөд 2022 оны 2-р улирлаас 14 давхар орон сууцны угсралтын ажил эхэлж гүйцэтгэлийн шатанд явж байна.

2024 оны байдлаар Хан-Уул дүүргийн 4-р хороонд 24 давхар үйлчилгээний цогцолбор, 360 айлын "ЭНХ ТӨГӨЛ" хотхоны бүрэн цутгамал 5 блок орон сууц, Нүхтийн аман дахь спорт заал, ХУД 4-р хороо 24 давхар оффисын барилга, ХУД Шунхлай плаза цогцолбор, ХУД Жаргалантын аманд 16 хаус хотхон, БЗД 11-р хороо "Бага тэнгэр"ийн аманд бүрэн цутгамал зочид буудал зэрэг төслүүд дээр амжилттай ажиллаж байна.

## Үйлдвэрийн барилга угсралт

Энгийн болон тусгай зориулалтын химийн агуулах, архи пиво, суу, цэвэр ус зэрэг хүнсний үйлдвэрийн зориулалттай барилгын 7 төсөл амжилттай хэрэгжүүлсэн.

## Уул уурхайн зориулалттай барилга

Уул уурхайн энгийн болон тусгай зориулалттай химийн агуулахын төсөл 2021-2024 онуудад үргэлжлэн хийгдэж байна. Зам гүүрний, сантехникийн, цахилгааны, холбооны, агааржуулалт салхивч, халаалт угсралтын өндөр мэргэшсэн инженерийн баг манай хэрэгжүүлж буй бүх төслийн хүрээнд өөрийн хариуцсан нэгжийг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж байна.

## Тээвэр, ложистик

2017 оноос эхлэн өөрийн компанийн 100% хөрөнгө оруулалтаар 4 ширхэг VOLVO, SCANIA зүтгүүр, 4ш 90 тонн чиргүүлийн хамтаар худалдан авч олон улсын тээвэрт БНХАУ-ын Эрээн хотоос Улаанбаатар чиглэлд тогтмол тээвэр хийн өөрийн болон захиалагч компанийн бараа материалын хангамжийг тасалдалгүй ханган ажиллаж ирсэн.



2022-2023 он. Оюу Толгой дахь  
"ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АГУУЛАХ"





# МАНАЙ БАГ

## Үдирдлагын бүрэлдэхүүн

Монгол Улсын Зөвлөх Инженер-1 /25 жилийн туршлагатай/  
Архитектор-1 /15 жилийн туршлагатай/  
Барилгын талбайн болон хяналтын инженер-4 /~18 жилийн туршлагатай/  
Барилгын зургийн инженер-2 /~18 жилийн туршлагатай/  
Барилгын төсөвчин-1 /20 жилийн туршлагатай/  
ХАБЭА инженер-3 /~16 жилийн туршлагатай/  
Цахилгааны инженер-1 /16 жилийн туршлагатай/  
Сантехникийн инженер-1 /14 жилийн туршлагатай/  
Холбооны инженер-1 /19 жилийн туршлагатай/  
Агааржуулалт салхивч, халаалтын инженер-1 /15 жилийн туршлагатай/  
Хүнд даацын авто механик-1 /20 жилийн туршлагатай/

## Барилга угсралтын баг

Мэргэшсэн аргон гагнуурчин-1 /20 жилийн туршлагатай/  
Мэргэшсэн цахилгаан гагнуурчин-2 /~15 жилийн туршлагатай/  
Барилгын мэргэшсэн мужаан-8 /~12 жилийн туршлагатай/  
Барилгын мэргэшсэн өрлөгчин-6 /~16 жилийн туршлагатай/  
Барилгын мэргэшсэн дотор засалч-15 /~16 жилийн туршлагатай/  
Барилгын мэргэшсэн өргөгч оператор-12 /~16 жилийн туршлагатай/  
Барилгын мэргэшсэн цахилгаанчин-5 /~13 жилийн туршлагатай/  
Барилгын мэргэшсэн сантехникч-30 /~15 жилийн туршлагатай/  
Төмөр хийцийн ажилтан-40 /~15 жилийн туршлагатай/  
Туслах ажилтан-12 /~8 жилийн туршлагатай/  
Мэргэшсэн жолооч-4 /~15 жилийн туршлагатай/

# ТЭЭВЭР, ЛОЖИСТИК

2017 оноос эхлэн өөрийн компаний 100% хөрөнгө оруулалтаар 4 ширхэг VOLVO, SCANIA зүтгүүр, 4 ширхэг 90 тонн чиргүүлийн хамтаар худалдан авч олон улсын тээвэрт БНХАУ-ын Эрээн хотоос Улаанбаатар чиглэлд тогтмол тээвэр хийн өөрийн болон захиалагч компаний бараа материалын хангамжийг тасалдалгүй ханган ажиллаж ирсэн.





+976-9111-7989



УЛААНБААТАР ХОТ, ХАН УУЛ ДҮҮРЭГ 24-ХОРОО, ДРИЙМ ПЛАЗА,  
401 ТООТ



info@tuvshinbogd.mn

